



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 148

Улаанбаатар хот

“Зохицуулалтын үйлчилгээний хөлс төвлөрүүлэх хугацааг хойшлуулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.5, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох, төвлөрүүлэх журмыг шинэчлэн батлах тухай” 211 дүгээр тогтоолын 3, 4 дүгээр хавсралтад заасан банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын үйлчилгээний хөлс төвлөрүүлэх хугацааг 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хойшлуулсугай.

2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан 2019 оны 211 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан “Зохицуулалтын үйлчилгээний хөлсийг төвлөрүүлэх журам”-ын 3 дугаар бүлгийн 3.3 дахь хэсгийн банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоонд холбогдох үйлчлэлийн хугацааг 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд түр зогсоосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлж ажиллахыг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН